



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/04

Ховд

Г Газар эзэмших эрх шилжүүлэх тухай Г

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Жаргалан багийн 1 дүгээр гудамжны 29 тоотод байрлах шатахуун түгээх станцын зориулалттай “Хөрс авто сервис” ХХК /2090694/-ийн эзэмшлийн 1738.0 метр квадрат газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 432 метр квадрат газрыг Чүлтэмийн Ганчимэг /ПБ70030909/-д шилжүүлэн хаягийг Залуус 4 дүгээр гудамжны 401 а тоот, худалдаа үйлчилгээний зориулалттай болгон 15 жилийн хугацаатайгаар, үлдсэн 1306 метр квадрат газрыг “Хөрс авто сервис” ХХК /2090694/-д хаягийг Залуус 4 дүгээр гудамжны 401 тоот болгон 3 жилийн хугацаатайгаар,

2.Жаргалант сумын Буянт багийн 10000-ын урд байрлах нэг загварын орон сууцны зориулалттай Зандраагийн Амгаланбаатар /ПЭ73020613/-ийн эзэмшлийн 400.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Намралын Баттөмөр /ПЭ70010159/-д мэдээллийн сангийн зургийн дагуу 425 метр квадрат, хаягийг Цэцэрлэгт хүрээлэн 1 дүгээр гудамжны 154 а тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 3 жилийн хугацаатайгаар,

3.Жаргалант сумын Магсаржав баг, хуучнаар “Бава” төийн үйлчилгээний зориулалттай “Бууч трейд” ХХК /2048078/-ийн эзэмшлийн 1750.0 метр квадрат

Zax A/04 Ch


02 00015

газраас газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу 645 метр квадрат газрыг Даваажавын Батбаяр /ПЮ72071116/-д шилжүүлэн хаягийг Лааганы 1 дүгээр гудамжны 117 а тоот болгон, худалдаа үйлчилгээний зориулалтгаар 8 жилийн хугацаатайгаар, үлдсэн 1105 метр квадрат газрыг “Бууч трейд” ХХК /2048078/-д хаягийг Лааганы 1 дүгээр гудамжны 117 тоот болгон 8 жилийн хугацаатайгаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

4.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгж байгууллагад үүрэг болгосугай.

5.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуй нэгж байгууллагад газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ